



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 01 сарын 10 өдөр

Дугаар А/02

Чингис хот

Ерөнхий боловсролын сургуулийн
сурагчдын ээлжийн амралтыг сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29-дүгээр зүйлийн 29.2, 28 дугаар зүйлийн 28.1.3, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.10, Эрүүл мэндийн сайдын 2014 оны Томуу, томуу төст өвчний харуулдан тандалтын тогтолцоог өргөжүүлэх тухай 358 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан Томуу, томуу төст өвчний улирал угтаж болон дэгдэлтийн үед авах арга хэмжээний журмын 3.1, 3.2, 3.6 дахь заалт, 2017 оны Төлөвлөгөө батлах тухай 346 дугаар тушаалын хавсралтын 2 дахь заалт, аймгийн Засаг даргад эрх шилжүүлсэн тухай Соёл, шинжлэх ухаан, спортын сайдлын 2020 оны А/05 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд томуу, томуу төст өвчлөл нэмэгдэж, 2020 оны 01 дүгээр 7 хоногийн мэдээгээр амбулаторийн нийт үзлэгийн 11.2 хувь, яаралтай тусламжийн дуудлагын 30.1 хувийг эзэлж, өвчний ноцтой хүндрэл гарч байгаатай холбогдуулан аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын ээлжийн амралтыг 2020 оны 01 дүгээр сарын 20-ийг хүртэл сунгасугай.

2. Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчлөлийг бууруулах, иргэдэд зориулсан мэдээлэл, сургалт сурталчилгааг эрчимжүүлэн, бэлэн байдлыг хангаж ажиллахыг Эрүүл мэндийн байгууллагын дарга, эрхлэгч нарт даалгасугай.

3. Ерөнхий боловсролын сургуулийн ээлжийн амралтыг сунгасантай холбоотой Соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны А/05 дугаар тушаалыг хэрэгжүүлж ажиллахыг Боловсрол, соёл, урлагийн газрын дарга /С.Мөнхцэцэг/-д даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга /Г.Лхагвахатан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ

Г.ХЭРЛЭНЧУЛУУН



231010001